

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ ИРГЭДЭЭС ХАНДАЖ  
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,ГОМДОЛ,САНАЛ, ХҮСЭЛТИЙН МЭДЭЭ,ТАЙЛАН  
/2018 оны 1 дүгээр улирлын байдлаар/**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо	Шийдвэрлэлт					Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Шийдвэрлэх шатандаа	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	ГХБХБГазар	975	962	-	7	-	6	-
	<b>Нийт</b>	<b>975</b>	<b>962</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>98.6%</b>

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ ИРГЭДЭЭС  
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН САНАЛ, ХҮСЭЛТ,  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

/2018 оны 1 дүгээр улирлын байдлаар/

2018 оны 03 дугаар сарын 23 Чойр хот

№	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт тоо	Хэлбэр					Агуулга					Шийдвэрлэж хариу өгсөн		Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Шийдвэрлэж байгаа	
			Амаар	Бичгээр	Утсаар	Цахим хэлбэрээр	Дээд байгууллагаас ирсэн	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа хэтэрч хариу өгсөн		Хугацаа болоогүй	Шийдвэрлэх шатандаа
1	Ажилд орох хүсэлтийн тухай	3		3					3			3					
2	Жирэмсний амралт олгох тухай	1		1					1			1					
3	Ажлаас чөлөөлөгдөх тухай	1		1					1			1					
4	Чөлөө авах тухай	2		2					2			2					
5	Цалинтай чөлөө олгох тухай	2		2					2			2					
6	Шинээр төрсөн хүүхдийн тэтгэмж олгох хүсэлт	1		1					1			1					
7	Сургалтын зардал шийдвэрлүүлэх тухай	1		1					1			1					
8	Газар хэмжүүлэх тухай	8		8					8			8					
9	Гомдол хүргүүлэх тухай	1		1					1			1					
10	Хүсэлт гаргасан	3		3					3			3					

11	Газар эзэмших эрх хүссэн тухай	11		11					11			2			3	6
12	Эзэмшил газрын гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай	12		12					12			12				
13	Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах тухай	40		40					40			40				
14	Барьцаа чөлөөлөх тухай	1		1					1			1				
15	Газар өмчлөх эрх шилжүүлэх	5		5					5			2			3	
16	Газар эзэмших эрхээ өмчлөл болгуулах хүсэлт	2		2					2			1				1
17	Газар өмчлөх эрх хүссэн	881		881					881			881				
<b>Нийт дүн</b>		975		975					975			962			6	7

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2018 оны  
1 дүгээр улирлын өргөдөл, гомдол барагдуулалтын тайлан**

2018.03.23

ГХБХБГазарт 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар албан хаагчдаас, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 984 өргөдөл манай байгууллагад ирүүлсэн байна. Үүнээс:

Газрын үйл ажиллагаатай холбоотой 969, удирдах албанд 14, барилгын хэлтэст 1 өргөдөл тус тус ирсэн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98.6%-тай байна.

Аймгийн газрын удирдлагын хэлтэст: 53 өргөдөл, гомдол ирснээс:

Газар өмчлөх болон газар эзэмших, ашиглахтай холбоотой өргөдлүүдийг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээг авч ажилласан. Үүнээс:

1. Шинээр газар эзэмших хүсэлт ирүүлсэн 2 ИААНБ-ын хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан.
2. Газар өмчлөх эрхээ өвлөхөөр шилжүүлэх 3 хүсэлт ирснээс 2 иргэний хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэж, 1 иргэний хүсэлт шийдвэрлэх шатандаа байна.
3. Газар эзэмших эрхийг шилжүүлэх 8 өргөдөл хүлээн авснаас аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.
4. Газар барьцаалах 33 хүсэлт ирүүлснийг тухай бүрд нь шийдвэрлэсэн.
5. Газар хэмжүүлэх нийт 7 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдлийн дагуу байгууллагаас баталсан хэмжилт хийх хувиарын дагуу газар дээр нь очиж хэмжилт хийж эргэлтийн цэгүүдийг тэмдэгжүүлж зааж өгсөн.

Сүмбэр сумын Газрын даамалд 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 511 өргөдөл ирүүлсэн байна. Үүнээс:

1. Шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлөх өргөдөл 504 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлээд байна.
2. Газар эзэмших эрхийг барьцаалах 3 иргэний хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан байна.
3. Газар эзэмших эрхийг шилжүүлэх 2 өргөдөл хүлээн авч Сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.
4. Газар эзэмших эрхээ өмчлөл болгох хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийг хүлээн авч 1 иргэний хүсэлтийг сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэж, 1 иргэний хүсэлтийг шийдвэрлэх шатандаа байна.

Шивээговь сумын Газрын даамалд 2018 оны 1 дугаар улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 259 өргөдөл ирүүлсэн байна. Үүнээс:

**Газрын харилцааны асуудлаар ирсэн өргөдөл, санал, гомдол шийдвэрлэсэн байдал:**

1. Шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлөх өргөдөл 250 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлээд байна.

2. Газар өмчлөх эрх шилжүүлэх 2 өрхийн өргөдлийг хүлээн авч сумын Засаг даргын захирамжийг гаргахаар ажиллаж байна./хугацаа болоогүй байна./
3. Шинээр газар эзэмших эрх хүссэн 3 иргэний өргөдлийг шийдвэрлэх хуулийн дагуу судлаж байна. /хугацаа болоогүй байна./
4. Газар эзэмших эрхийг шилжүүлэх 2 өргөдөл хүлээн авч Сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.
5. Газар барьцаанаас чөлөөлөх 1 өргөдөл ирүүлснийг шийдвэрлэсэн.
6. Газар хэмжүүлэх 1 иргэн хүсэлт гаргасны дагуу бүртгэн аймгийн геодезийн мэргэжилтэнээр хэмжүүлэхээр ажиллаж байна./хугацаа болоогүй байна./

Баянтал сумын газрын даамалд 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэдээс нийт 137 өргөдөл ирүүлсэн байна. Үүнээс:

1. Баянтал суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлөх хүсэлт гаргасан нийт 127 иргэний хүсэлтийг шийдвэрлээд байна
2. Газар эзэмших эрхийг барьцаалах 4 иргэний тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан байна.
3. Хороо бууцны газар эзэмших хүсэлт гаргасан 6 иргэний өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.

#### **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**